

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ Т.БОЛОРЧИМЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх							
1.	Арга хэмжээ 1.1. Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2023 оны үйл ажиллагааны	Үнэлгээний дүн, тайлан		Үнэлгээний дүнг УАЗ-нд танилцуулсан байна.	Эрүүл мэндийн байгууллагуудын 2023 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргаар 2024.01.12-ны өдөр батлуулсан. Ажлын хэсэг үнэлгээг 2024 оны 1-р улиралд багтаан гүйцэтгэсэн ба ЭМЯ-ны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ-үүд 78.8%-ийн гүйцэтгэлтэй, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газрууд 79.4%-ийн гүйцэтгэлтэй, Салбарын хэмжээнд 2023 оны гүйцэтгэл 79.1% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэв. Үнэлгээний дүн 2024.03.29-ны өдөр зохион байгуулагдсан Салбарын Удирдах ажилтны зөвлөгөөнд	2024.01.01 2024.03.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх				танилцуулсан. Тайлан, зөвлөмжийг харьяа байгууллага, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, БОЭТ болон 21 аймгийн Эрүүл мэндийн газарт 2024.04.04-ны 1а/1354 тоотой, хүргүүлсэн. ЭМЯ-ны газар хэлтсүүдэд 2024.04.01-ний өдрийн №69 тоот дотоод меморандумаар үнэлгээний нэгдсэн тайлан, зөвлөмжийг хүргүүлсэн.		
2.	Арга хэмжээ 1.2. Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Үнэлгээний дүн, тайлан		Үнэлгээний дүн, зөвлөмжийг ЭМБ-д хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн чанарын үзүүлэлтийн биелэлт ирүүлэх 2024.05.28-ны 9/2276 тоотыг хүргүүлж, тайланг нэгтгэж гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэсэн. Үнэлгээрээ харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ-ийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт 63.2%; аймаг нийслэлийн ЭМГ-ийнх 59.8%; Салбарын хэмжээнд 61.5% буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдэв. Тайлан, зөвлөмжийг 2024 оны 6 дугаар сарын өдрийн 17-ны 2/2659 тоотой хүргүүлсэн. Мөн ЭМБ-уудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажиллах тухай №129 тоот дотоод меморандумыг ЭТҮГ, НЭМГ-т хүргүүлсэн.	2024.01.01 2024.06.30	100
3.	Арга хэмжээ 1.3. Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд	Үнэлгээний дүн, тайлан		Үнэлгээний дүн, зөвлөмжийг ЭМБ-д	Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд явцын хяналт үнэлгээ хийх удирдамжийг Эрүүл мэндийн сайдаар 2023.04.01-ний өдөр батлуулсан. Хяналт үнэлгээг ХШҮДАГ-аас	2024.01.01 2024.06.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	явцын хяналт, үнэлгээ хийх үнэлгээ хийх			хүргүүлсэн байна.	2 хүний бүрэлдэхүүнтэй баг 2024.5.19-нөөс 2024.05.25-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Үнэлгээнд удирдамжийн дагуу удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, тусламж үйлчилгээний чанар, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, ил тод байдлын хэрэгжилт зэрэг асуудлыг хамруулсан ба үнэлгээ хийх явцад газар дээр нь засч залруулах зөвлөмжийг Эрүүл мэндийн газрын удирдлагууд болон Нэгдсэн эмнэлэг, Сумын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвд танилцуулж ажилласан. Үнэлгээний тайланг боловсруулж нэгжийн даргад танилцуулсан. Үнэлгээний тайлан, зөвлөмжийг 2024.07.08-ны 8/2905 тоотоор Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэв.		
4.	Арга хэмжээ 1.4. Эрүүл мэндийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хагас жилийн байдлаар явцын хяналт, үнэлгээ хийх	Үнэлгээний дүн, тайлан		Үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулсан байна.	Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолоор батлагдсан журмын дагуу Эрүүл мэндийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр №124 тоот дотоод меморандумыг ТЗУГ-т хүргүүлж, ирүүлсэн тайланг нэгтгэж үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээрээр Эрүүл мэндийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт хагас жилийн байдлаар 59% буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн. Үнэлгээний дүнг 2024.07.23-ны өдрийн УЗХ-д танилцууж, хурлаас 0-30% хэрэгжилттэй үйл ажиллагааг эрчимжүүлэхийг нэгжийн дарна нарт үүрэг болгосон шийдвэр гарсан. УЗХ-аас гарсан	2024.01.01 2024.07.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					шийдвэрийг №179, 180, 181, 182, 183 тоот дотоод меморандумаар газар хэлтсүүдэд хүргүүлсэн.		
	Арга хэмжээ 1.5. Эрүүл мэндийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Үнэлгээний дүн		Үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулсан байна.	Засгийн газрын 206-р тогтоолоор батлагдсан журмын дагуу Эрүүл мэндийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөгөөний нэгтгэлийг ХШҮДАГ-т ирүүлэх тухай 2024.12.02-ны өдрийн №340 тоот дотоод меморандумыг ТЗУГ-т хүргүүлээд байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу 12 дугаар сарын 15-ны дотор газар, хэлтсүүд тайланг ирүүлэх ба үнэлгээг хийж, 12 дугаар сарын 25-нд УЗХ-д танилцуулав./ХБГ/	2024.01.01 2024.12.31	100
5.	Арга хэмжээ 1.6. Санхүүжилт, удирдлагын хагас бие даасан байдалтай уялдуулан эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийн төлөвлөлтийн хэрэгжилтийн явцад хяналт, үнэлгээ хийх	Үнэлгээний дүн		Үнэлгээ хийгдэж, зөвлөмж хүргэгдсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан ба уг төлөвлөгөөний 2.1.7.6-д санхүүжилтийн гүйцэтгэл, удирдлагын хагас бие даасан байдалтай уялдуулан эрүүл мэндийн байгууллагууд хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.1.1.5 дах заалтыг үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудын стратеги	2024.01.01 2024.06.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт үнэлгээ хийж гүйцэтгэлээ. 2024 оны 5 дугаар сарын байдлаар үнэлгээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явц дунджаар 79,2% буюу тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа гэж үнэлэгдлээ. Үнэлгээний дүн, тайланг 2024 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 8/2709 тоотой эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэв.		
Зорилт 2. Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх							
2.1	Арга хэмжээ 2.1. Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулсан 2023 оны гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Үнэлгээний дүн, тайлан		Үнэлгээний дүнг 2024.03.01-ны дотор ЗГХХГ-т хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2024.02.26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийн дундаж 75.9% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэв. Үнэлгээний дүнг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан www.new.unelgee.gov.mn -д аймаг тус бүрээр оруулсан ба нэгдсэн танилцуулга, дүнг 2024.02.28-ны өдрийн 1а/856 тоотой Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэв.	2024.01.01 2024.03.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
2.2	Арга хэмжээ 2.2. Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2024 оны гэрээний ЭМТҮ-ний чанарын үзүүлэлтийн эхний хагас жилийн биелэлтэд ХШҮ хийх	Үнэлгээний дүн, тайлан		Үнэлгээний дүнг УЗХ-д танилцуулсан байна.	Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд 2024 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний чанарын үзүүлэлтийн хэрэгжилт ирүүлэх тухай 2024.05.28-ны 9/2276 тоотыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн ба ирүүлсэн тайланг нэгтгэн үнэлгээг гүйцэтгэсэн. Үнэлгээгээр Засаг дарга нартай байгуулсан 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 49% буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдэв. Үнэлгээний дүнг 2024.06.13-ны өдрийн УЗХ-аар хэлэлцүүлсэн. Хурлын шийдвэр, тайлан, зөвлөмжийг 2024.06.17-ны өдрийн 2/2659 тоотоор аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Мөн хурлын шийдвэрийг ЭМЯ-ны холбогдох газар хэлтэст №129 тоот меморандумаар хүргүүлэв.	2024.01.01 2024.06.30	100
Зорилт 3. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх							
3.1	Арга хэмжээ 3.1 Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Үнэлгээний дүн, тайлан		Үнэлгээний дүнг 2025.01.01-ны дотор ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна.	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан Эрүүл мэндийн салбарын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээ хийхээр хөрөнгө оруулалтын мэдээг 12 дугаар сарын 10-ны дотор ХШҮДАГ-т ирүүлэх тухай №336 тоот дотоод меморандумыг СЭЗГ, ХОХ-д хүргүүлээд байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний дүн тайланг 2025 оны 1 дүгээр сарын 01-нд тоотоор ЭЗХЯ-нд хүргүүлэв. /ХБГ/	2024.01.01 2024.12.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх							
	Арга хэмжээ 4.1. Шинэ сэргэлтийн бодлогын 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Үнэлгээний дүн		Үнэлгээний дүнг ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна	Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагаанд хамаарах эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлж байгаа 18 арга хэмжээг нэгтгэн үнэллээ. Үнэлгээгээр эдгээр үйл ажиллагааны хэрэгжилтийн дундаж 82.5% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэв. Үнэлгээний дүн, тайланг УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолын дагуу 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 1а/3555 тоотойр Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлэв.	2024.01.01 2024.09.01	100
	Арга хэмжээ 4.2 Эрүүл мэндийн яаманд дахь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх	Үнэлгээний дүн		Үнэлгээний дүнг Сангийн яаманд хүргүүлсэн байна.	Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан “Төрийн хэмнэлтийн тухай” хуулиар төрийн бүх шатны байгууллагын үйл ажилагаанд хангамж, зарим үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоосон. Иймд уг хуулийн хэрэгжилтийг үнэлэн дүгнэх, цаашид авах арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулахаар үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээгээр Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаан дахь Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт 87,1%, салбарын хэмжээнд хуулинд хамрагдах 5 байгууллагын дундаж 91,8% буюу “хангалттай” хэрэгжиж байгаа гэж үнэлэгдэв. Үнэлгээний дүн, тайланг 2024 оны 11	2024.01.01 2024.12.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					дүгээр сарын 20-ны өдрийн 1а/4846 тоотой Сангийн сайдад хүргүүлэв.		
	Арга хэмжээ 4.3 Эрүүл мэндийн салбарын худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт, үнэлгээ хийх	Үнэлгээний дүн		Үнэлгээний дүнг УЗХ-д танилцуулсан байна.	Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2024 оны хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээгээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, зохион байгуулалт, тайлагнахтай холбоотой үйл ажиллагааны хэрэгжилт 84,1% буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдлээ. Үнэлгээний тайлан зөвлөмжийг СЭЗГ-т Дотоод Меморандумаар хүргүүлэв.	2024.01.01 2024.12.31	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
2.	Үүрэг даалгавар 1. Төрийн нарийн бичгийн даргын 2024.01.08-ны өдрийн баталсан	Хяналт шинжилгээний тайлан		Тайланг ТНБД, Эрүүл мэндийн сайдад танилцуулна	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хүний эрх, ёс зүй, байгууллагын төсөв, санхүү, хүний нөөцийн томилгоотой холбоотой үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, тулгамдаж буй асуудал, зөрчил,	2024.01.01 2024.02.01	100

2

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	удирдамж. Удирамжийн дагуу СЭМҮТ-ийн зарим асуудалд хяналт шинжилгээ хийх				дутагдлыг илрүүлж, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулах зорилгоор ажлын хэсэг 2024.01.09-нөөс 2024.01.17-ны хооронд ажилласан. Ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар ажиллаж, бүх тайланг эмхэтгэн боловсруулж, эцэслэсэн тайланд гишүүдээр гарын үсэг зуруулж, мөн танилцуулгыг ppt хэлбэрээр бэлтгэн сайдад танилцуулахаар Ажлын хэсгийн ахлагч НЭМТГ-ийн ХБӨХ-ийн дарга Г.Ганхуягт хүлээлгэн өгсөн.		
3	Үүрэг даалгавар 2. ЗГХХГ, ЭМЯ хамтарсан 2024.02.02-ны өдрийн А/11 дугаар тушаал. Эрүүл мэндийн салбарын процессын дахин инженерчлэлтэй холбоотой ХШҮ-ний баримт материал бэлтгэх, хүлээлгэн өгөх	Хүлээлгэн өгсөн материал		Хүлээлгэн өгсөн байна.	ЗГХХГ, ЭМЯ хамтарсан 2024.02.02-ны өдрийн А/11 тушаалын дагуу: 1. Эрүүл мэндийн яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2021-2023 оны хагас, бүтэн жилийн ХШҮ-ний тайлан 2. Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн 2021-2023 оны хагас, бүтэн жилийн ХШҮ-ний тайлан 3. Засаг даргын гэрээний хэрэгжилтэд хийсэн 2021-2023 оны хагас, бүтэн жилийн ХШҮ-ний тайлан 4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн 2021-2023 оны ХШҮ-ний тайлан 5. Шинэ сэргэлтийн бодлогын 2022-2023 оны хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан 6. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 2022-2023 оны ХШҮ-ний тайлан	2024.02.01 2024.04.01	100

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					7. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн 2022-2023 оны ХШҮ-ний тайлан 8. 2021-2023 онд нэмэлтээр хийж гүйцэтгэсэн бусад ХШҮ-ний тайлан зэрэг 8 чиглэлийн 44 тайлангийн 1739 хуудас матераилыг PDF хэлбэрт шилжүүлэн ЗГХХГ-ын хариуцсан ажилтанд хүлээлгэн өгсөн. Холбогдох чиглэлээр ажлын хэсэгтэй уулзалт хийж, тайлбар танилцуулга өгсөн		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Удирдлагын академиас зохион байгуулах Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад хамрагдах	Сургалт		Сургалтад хамрагдсан байна	Төрийн нарийн бичгийн даргын 2024.03.11-ний өдрийн А/23 дугаар тушаалын дагуу Удирдлагын академийн Ахлах түшмэлийн багц сургалтад хамрагдаж төгссөн. Сургалт 2024.03.01-2024.06.20-ны хооронд үргэлжилсэн ба сургалтыг амжилттай дүүргэж, Удирдлагын академийн захирлын 2024 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн А/435 дугаар тушаалаар №А4758 тоот сертификат авав.	2024.03.01 2024.07.10	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шаг, уур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
2.	Арга хэмжээ 2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр чадавхжуулах сургалтад хамрагдах	Сургалт		Сургалтад хамрагдсан байна	Азийн хөгжлийн банкны Үнэлгээ миониторингийн хэлтэс болон Монгол дахь Төлөөлөгчийн газар хамтран зохион байгуулсан “Төслийн үнэлгээ” сэдэвт сургалтад 2024.03.11-2024.03.16-ны хооронд хамрагдаж 2024/03 Сертификат авав.	2024.03.11 2024.04.01	

ТАЙЛАН ГАРГАСАН:

.....
(Албан тушаал)

Т.Болорчимэг / /
(Нэр, гарын үсэг)

2024.12.05-ны өдөр
(Огноо)